



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 308.168

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ-ийн гишүүн элсүүлэх, бүртгэх, гишүүнчлэлийг сунгах журам”-ыг шинэчлэн өөрчилж хавсралт ёсоор баталсугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО” НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГИШҮҮН ЭЛСҮҮЛЭХ, БҮРТГЭХ, ГИШҮҮНЧЛЭЛИЙГ СУНГАХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь “Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд (цаашид “Мэргэжлийн нэгдсэн холбоо” эсхүл “МНХ” гэх)-д гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнээр элсүүлэх, бүртгэх, хяналт тавих, гишүүнчлэлийн хугацааг сунгах, хасах болон гишүүнчлэлийн татвартай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Мэргэжлийн нэгдсэн холбоонд бүртгүүлэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нь Аялал жуулчлалын тухай хууль, аялал жуулчлалын салбарын мэргэжлийн ёс зүйн дүрэм, Мэргэжлийн нэгдсэн холбооны зорилго, зарчим, дүрэм болон холбогдох журамтай танилцаж, хүлээн зөвшөөрсөн гарын үсэг, цахимаар танилцсан тохиолдолд зөвшөөрсөн тэмдэглэгээг дарна.

1.3.Мэргэжлийн нэгдсэн холбоонд дараах байгууллага, хувь хүн гишүүнчлэлтэй байна:

1.3.1.Тур оператор;

1.3.2.Аяллын агент;

1.3.3.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага;

1.3.3.1. Зочид буудал;

1.3.3.2. Аялал жуулчлалын цогцолбор;

1.3.3.3. Жуулчны базз;

1.3.3.4. Аялал жуулчлалын багш судлаач;

1.3.3.5. Жуулчин тээвэр;

1.3.3.6. Соёл урлагийн байгууллага;

1.3.3.7.Кофе шоп;

1.3.3.8.Ресторан, зоогийн газар;

1.3.3.9.Бэлэг дурсгалын байгууллага;

1.3.3.10.Амралтын газар;

1.3.4.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч;

1.3.5.Жуулчны хөтөч-тайлбарлагч;

1.3.6.Аялал жуулчлалын салбарын холбоо (цаашид “гишүүн” гэх)-д тус тус

байна.

1.4. Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн нь үйл ажиллагааны чиглэл, байршлын бүс нутаг, зорилтот зах зээл зэргээс хамааран дараах салбар холбоонд харьяалагдана. Үүнд:

1.4.1. тур оператор нь Тур операторуудын зах зээлийн салбар холбоо, Аймгийн холбоо болон Адал явдалт аялал жуулчлалын салбар холбоонд;

1.4.2. аяллын агент нь Агентын салбар холбоонд;

1.4.3. жуулчны бааз нь Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо болон Аймгийн холбоонд;

1.4.4. зочид буудал нь Зочид буудлын салбар холбоо болон Аймгийн холбоонд;

1.4.5. нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч нь Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн салбар холбоо болон бусад салбар холбоонд тус тус харьяалагдана.

1.5. Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн нь нэгдсэн хуралдаанд бие даасан саналын эрхгүй ба өөрийн нэгдэн орсон салбар холбооны саналын эрхэнд нэгдсэн байна.

ХОЁР.ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Мэргэжлийн нэгдсэн холбоонд иргэн, хуулийн этгээд нь сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэнэ.

2.2. Мэргэжлийн нэгдсэн холбоонд гишүүнээр элсэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэл, татвар, нийгмийн даатгалын болон бусад төрийн эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн байх;

2.2.2. Аялал жуулчлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан байх;

2.2.3. гишүүнчлэлийн хураамж төлсөн байх.

2.3. Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн жуулчны хөтөч-тайлбарлагч нь Аялал жуулчлалын тухай хууль, холбогдох дүрэм, журамд заасан шаардлагыг хангаж, мэргэжлийн үнэмлэх авсан байна.

2.4. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд гишүүнээр элссэн хувь хүн, байгууллага нь жил бүр Мэргэжлийн нэгдсэн холбооноос явуулж буй ажил, сургалт, судалгаанд тогтмол хамрагдана.

2.5. Гишүүн нь дээд тал нь МНХ-ны 3 (гурван) салбар холбоонд харьяалагдана.

ГУРАВ.ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТАТВАР

3.1. Мэргэжлийн нэгдсэн холбоонд гишүүн болох хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нь тухайн жилд шинээр гишүүнээр элсэх хүсэлтээ гаргаж, энэхүү журамд заасны дагуу бүртгүүлсэн улирлаас эхлэн тухайн жил дуусах хүртэл хугацааны татварыг төлнө.

3.2.Гишүүн нь хоёр дахь жилээс эхлэн тухайн жилийн Гишүүнчлэлийн татварыг бүрэн хэмжээгээр нэгдүгээр улиралд багтаан МНХ-ны Нэгдсэн хуралдаанаас тогтоосон дүнгээр төлнө.

3.3.Гишүүн нэгээс дээш салбар холбоонд харьяалагдсан нөхцөлд салбар холбоонд хуваарилагдах гишүүнчлэлийн татварыг хуваан шилжүүлнэ.

3.4.Гишүүн гурваас дээш салбар холбоонд элссэн тохиолдолд 200,000 (хоёр зуун мянган) төгрөгийн татвар нэмж төлнө.

3.5.Гишүүн саналын эрхгүй, татвар хуваарилагдахгүй салбар холбооны үйл ажиллагаанд зохих хураамжийг төлж оролцох эрхтэй байна.

3.6.Салбар холбоод өөрийн салбар холбоонд харьяалалгүй гишүүд, Мэргэжлийн нэгдсэн холбоо, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулж болно.

3.7.Гишүүд өөрийн харьяалалгүй салбар холбооны нээлттэй болон Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүдэд зориулан зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Хэрэв тухайн үйл ажиллагаа нь гишүүн бус иргэн, хуулийн этгээдэд оролцоход хураамж тогтоосон бол тухайн хураамжийг төлөх үүргийг хүлээнэ.

3.8.Гишүүн жил бүр татвараа төлөхдөө өөрийн салбар холбоогоо дахин сонгож болно.

ДӨРӨВ.ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ

4.1.Гишүүнээр элсэх хүсэлт гаргаж буй этгээд гишүүнээр элсэх тухай өргөдлийг Мэргэжлийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлөөс баталсан маягтын дагуу бэлтгэж, энэхүү журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан талаарх мэдээлэл, холбогдох баримт, бичгийг Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын албанд цахим хэлбэрээр ирүүлнэ.

4.2.Гишүүнээр элсэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нь Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнээр элсэх хүсэлт гаргасантай холбогдуулан шаардлагатай асуудлаар холбооны Ажлын албаны 77128822 дугаар болон Info@mto.mn цахим хаягаар тодруулга авч болно.

4.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь бүрдэл болон агуулгын аливаа зөрчилгүй баримт бичиг хүлээж авсан өдрийг хүсэлт гаргасан этгээдийн баримт бичгийг албан ёсоор хүлээж авсан өдөр гэж тооцох бөгөөд энэхүү өдрөөс эхлэн ажлын 5 өдрийн дотор гишүүнээр бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Ажлын алба ирүүлсэн хүсэлтийг хянан үзэж баримт бичгийн шаардлага хангасан эсэх хариуг иргэн, хуулийн этгээдэд цахимаар хүргүүлнэ.

4.4.Мэргэжлийн нэгдсэн холбоонд ирүүлсэн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт орсон бол хүсэлт гаргагч нь энэ тухай ажлын 3 (гурав) өдрийн дотор Мэргэжлийн нэгдсэн холбоонд мэдэгдэж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг ирүүлнэ.

4.5.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд гишүүнээр элсэхдээ холбогдох баримт бичгийг Монгол хэл дээр баталгаат орчуулгын байгууллагаар орчуулга хийлгэсэн байна.

4.6.Хүсэлт гаргагч этгээд нь Мэргэжлийн нэгдсэн холбоонд хүлээлгэн өгч буй баримт бичгийн бүрдэл болон үнэн зөв байдлыг хариуцна.

4.7.Хүсэлт гаргагч нь Мэргэжлийн нэгдсэн холбооны Удирдах зөвлөлөөс баталсан

гишүүний бүртгэлийн маягтыг бүрэн бөглөж хүсэлтэд хавсаргасан байна.

4.8.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь дараах тохиолдолд хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдээс нэмэлт мэдээлэл шаардана:

4.8.1.энэхүү журамд заасан гишүүнээр элсэх хүсэлт гаргаж буй этгээдийн өргөдөл, түүний хавсралт баримт бичгийг үнэн зөв эсэхийг нотлох зорилгоор нэмэлт баримт бичиг ирүүлэхийг шаардах;

4.8.2.гишүүнээр элсүүлэх хүсэлтэд хавсаргасан баримт бичиг эсхүл холбогдох мэдээллийг тодруулах;

4.8.3.нэмэлт мэдээлэл шаардсан бол энэ тухай хүсэлт гаргагч этгээдэд цахимаар эсхүл бичгээр мэдэгдэх ба хүсэлт гаргагч этгээд нэмэлт мэдээллийг албан бичигт заасан хугацаанд, хэрэв хугацаа заагаагүй бол ажлын 5 (таван) өдрийн дотор гаргаж өгнө.

4.9.Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын алба нь энэхүү журамд заасан нөхцөл шаардлага, баримт бичгийн бүрдэл, агуулга үндэслэн гишүүнээр элсүүлж бүртгэнэ.

4.10.Энэхүү журамд заасны дагуу тухайн иргэн, хуулийн этгээдийг гишүүнээр бүртгэсэн тохиолдолд энэ талаарх мэдээллийг Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын алба ажлын 3 (гурав) өдрийн дотор хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн бүртгүүлсэн цахим хаягаар мэдэгдэнэ.

4.11.Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын алба нь дараах тохиолдолд хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, түүний хавсралт баримт бичгийг хангалтгүй гэж үзэн баримт бичгийг хүсэлт гаргагчид буцаах, эсхүл нэмэлт шаардлага хүргүүлж болно. Үүнд:

4.11.1.энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй;

4.11.2.энэхүү журамд заасан баримт бичиг нь агуулга болон бүрдэлтийн хувьд зөрчилтэй, эсхүл Мэргэжлийн нэгдсэн холбооны шаардсан мэдээлэлтэй холбоотой мэдээлэл, холбогдох баримт бичгийг бүрэн ирүүлээгүй бол;

4.12.Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын алба нь гишүүнээр элсүүлэхээс татгалзах шийдвэр гаргасан бол холбогдох шийдвэрийг үндэслэл бүхий тайлбар хамт өргөдөл гаргагч этгээдэд бичгээр хүргүүлнэ.

4.13.Хүсэлт гаргасан этгээд гишүүнээр элсүүлэхээс татгалзах шийдвэрийг хүлээн авсан бол уг шийдвэрийг эс зөвшөөрсөн талаарх гомдлыг шийдвэр гарснаас хойш ажлын 10 (арав) хоногийн дотор Мэргэжлийн нэгдсэн холбооны Хяналтын зөвлөл (mto.supervisoryboard@gmail.com)-д мэйл хаягаар хандаж болох ба мөн энэ хугацаанд татгалзах шийдвэрт тусгагдсаны дагуу холбогдох бүрдлийг хангаж дахин хүсэлт гаргах эрхтэй.

4.14.Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын албанаас гишүүн бүрд гишүүний гэрчилгээ буюу ангиллын гэрчилгээ олгоно. Энэхүү журамд өөрөөр заагаагүй бол гишүүн өөрт олгосон гэрчилгээ, үнэмлэхийг бусдад ашиглуулах, дамжуулах, шилжүүлэхийг хориглоно.

4.15.Хүсэлт гаргасан этгээдийг гишүүнээр элсүүлсэн бол ангиллын гэрчилгээг долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гарагт 09:00-17:00 цагийн хооронд ажлын албаны “Гишүүнчлэл хариуцсан ажилтан”-аас ирж авна.

4.16.Гишүүний ангиллын гэрчилгээнд хүчин төгөлдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэл (оноосон нэр)-ийг бүртгэнэ.

4.17.Мэргэжлийн нэгдсэн холбоонд гишүүнээр элсэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нь гишүүнчлэлийн хураамжаа төлсөн боловч Удирдах зөвлөлөөс баталсан гишүүний бүртгэлийн маягт, холбогдох материалуудыг Мэргэжлийн нэгдсэн холбоонд хүлээлгэн өгөөгүй бол тухайн иргэн, хуулийн этгээдэд хураамж төлөгдсөн өдрөөс хойш 4 сарын хугацаанд холбогдох материалуудыг дахин ирүүлэх үүрэгтэй. Хэрэв гишүүнээр элсэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нь заасан хугацаанд материалаа ирүүлээгүй бол тухайн гишүүнчлэлийн хураамжийг буцаан төлөхгүй.

ТАВ.ГИШҮҮНЧЛЭЛИЙН БОЛОН АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭ СУНГАХ

5.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэмд заасны дагуу гишүүн нь жил бүр 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд өөрийн гишүүнчлэлийн болон ангиллыг гэрчилгээг сунгуулах хүсэлтээ Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын албанд ирүүлнэ.

5.2.Гишүүнчлэлийн болон ангиллын гэрчилгээ сунгах хүсэлтэд дараах материалыг хавсаргасан байна. Үүнд:

5.2.1.тухайн жил үйл ажиллагаа явуулсан болон Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаанд эсхүл салбар холбооны үйл ажиллагаанд оролцсон талаарх товч мэдээлэл;

5.2.2.тухайн жилийн гишүүнчлэлийн татвар төлсөн талаарх баримт (төлбөрийн гүйлгээний утга хэсэгт байгууллагын бүртгэлийн болон регистрийн дугаарыг бичнэ);

5.2.3.тухайн жилийн сунгах хугацаанд хүчинтэй даатгалын гэрээ;

5.2.4.татварын тодорхойлолт;

5.2.5.тухайн жилд хүлээн авсан жуулчны тоон мэдээлэл.

5.3.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн энэхүү журмын 5.1, 5.2-г заасан хүсэлт, холбогдох материалыг цахим хэлбэрээр ирүүлж болно.

5.4.Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын алба гишүүнчлэлийн болон ангиллын гэрчилгээ сунгах хүсэлтийг хянан үзэх явцад энэхүү журмын 4.8-д заасны дагуу нэмэлт мэдээлэл шаардаж болно.

5.5.Мэргэжлийн нэгдсэн холбооны ажлын алба гишүүнээс ирүүлсэн хүсэлт, холбогдох материалыг ажлын 3 (гурав) хоногт багтаан хянаж, гишүүнчлэлийн болон ангиллын гэрчилгээг сунгах эсэх хариуг хүргүүлнэ.

5.6. Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн ангиллын гэрчилгээг гэмтээсэн, ашиглах боломжгүй болсон, гэж үрэгдүүлсэн, ангилал нэмж шинээр авах, сунгалтын мөр дүүрч шинээр авах тус тус тохиолдолд гэрчилгээний мөнгө болох 20,000 (хорин мянган) төгрөгийг гэрчилгээ дахин хэвлэх, үнэт цаасны төлбөр төлнө.

5.7.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн энэ журмын 5.1 дэх хэсэгт заасан гишүүнчлэлийн сунгалт хийлгэх эцсийн хугацаанаас хойш 6 сарын дотор сунгалт хийлгээгүй тохиолдолд гишүүний мэдээллийг дотоод цахим системд идэвхгүй болгож,

олон нийтэд тухайн гишүүнчлэлээ сунгуулаагүй этгээдийн мэдээллийг харагдах боломжгүй төлөвт шилжүүлнэ.

5.8.Гишүүнчлэлийн сунгалт хийгдээгүй мэдээлэл нь харагдах боломжгүй төлөвт шилжсэн этгээд сунгалт хийлгэх тохиолдолд энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасны дагуу гишүүнээр элсэх үйл ажиллагааг эхнээс нь хэрэгжүүлж гишүүнээр элсэх хүсэлтийн хамт бүхий л шаардлагатай баримт бичгийг дахин шинээр гаргаж өгнө.

ЗУРГАА.БУСАД

6.1.Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Аялал жуулчлалын тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны нэгдэн орсон олон улсын байгууллагын дүрэм, журам, Мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм, холбогдох бусад эрх зүйн актаар зохицуулна.

6.2.Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд тухайн асуудлыг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

---oOo---